



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/112/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Ахлах аудитор: Э.Энхцэцэг Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn Аудитор: Б.Ариунбаатар Цахим хаяг: ariunbaatarb@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: domogovi@audit.gov.mn

2022.02.28 № 16/2022

танай _____-ны № _____-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГА Г.ЭНХЦЭЦЭГ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	282.2	751.6
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	870.0	897.2
	Нийт хөрөнгийн дүн	1,152.2	1,648.8
	Нийт өр төлбөрийн дүн	0.4	7.8
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,151.8	1,641.0
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,152.2	1,648.8
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	2,746.2	10,838.5
	Үйл ажиллагааны зардлын дүн	2,622.4	10,349.1
	Үйл ажиллагааны үр дүн	123.7	489.4
	Үйл ажиллагааны бус үр дүн	-0.5	-0.2
	Үйл ажиллагааны нийт үр дүн	123.2	489.2
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,151.8	1,151.8
	Тайлант оны үр дүн		489.2
	Эцсийн үлдэгдэл	1,151.8	1,641.0
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,310.9	3,913.2
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	2,301.4	3,912.1
	Үйл ажиллагааны ЦМГ	9.5	1.1
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-9.5	-1.1
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0.0	0.0
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.0	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		1,664.9
	Урсгал зардал		1,664.9
	Хөрөнгийн зардал		0.0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		1,664.9
	Улсын төсвөөс санхүүжих		1,664.9
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		0.00

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорноговь аймгийн Эрүүл мэндийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

1. Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомж, бодлого шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлэх
2. Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд орон нутгийн түвшинд нийгмийн эрүүл мэндийн бодлого, эмнэлгийн тусламж үйлчилгээ, эм эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хангамжийн талаар тавих зорилт, стратеги, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох тусламж үйлчилгээг оновчтой зохион байгуулах.

3. Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжлийн удирдлага арга зүйгээр хангах, үйл ажиллагаа бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гүйцэтгэлд хяналт шинжилгээ үнэлгээ хийж дүнг холбогдох байгууллагуудад мэдээлж ажиллах.
4. Орон нутгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний стратеги тэргүүлэх чиглэлд нийцүүлэн улсын болон орон нутгийн төсөв, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх хөрөнгийг үр ашигтай зарцуулах зарчмыг баримтлах.
5. Эрүүл мэндийн асуудлаар салбар дундын зохицуулалтыг хангаж, эрүүл мэндийг хамгаалах, дэмжих үйл ажиллагаанд орон нутгийн засаг захиргааны байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага олон улсын байгууллага, олон нийтийг оролцуулан хамтарч ажиллах.

Эрхэм зорилго: Хүн амын хэрэгцээнд нийцсэн чанартай, аюулгүй, хүртээмжтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нэвтрүүлэх

Алсын хараа: “Эрүүл аюулгүй амьдралыг хүн бүрт...” гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

Ковид-19 цар тахал өвчинтэй холбоотой засгийн газрын тогтоол, шийдвэрүүд шинээр гарч хэрэгжсэн.

Гурав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 142 мэдээллийг хугацаандаа оруулсан, 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийт 3,865.0 сая төгрөгийн 55 гүйлгээнээс 1,244.7 сая төгрөгийн 9 гүйлгээг мэдээлээгүй, зарлагын нийт 2,907.3 сая төгрөгийн 98 ажил гүйлгээнээс 131.7 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй, 270.0 сая төгрөгийн 6 гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан байна. Хөрөнгө зарцуулах 5,493.9 сая төгрөгийн 202 тушаал, шийдвэр гарсан ба системд 312.3 сая төгрөгийн 38 тушаал, шийдвэрийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Дөрөв. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Тав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 125.8 сая төгрөгийн 7 алдаа, зөрчил илэрснээс 116.9 сая төгрөгийн 4 алдааг залруулж, 0.9 сая төгрөгийн 1 зөвлөмж, 8.0 сая төгрөгийн 2 албан шаардлага өгсөн.

Залруулсан алдаа:

1. Эрүүл мэндийн төвүүдэд хуваарилсан 114.1 сая төгрөгийн хөрөнгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байсныг залруулав.

2. Тохируулах бичилтийг буруу хийснээс үр дүнгийн тайлангийн цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 0.2 төгрөгөөр хасагдсаныг залруулав.

3. Тайлант онд цалингийн тооцоололтой холбоотойгоор үүссэн өглөгийг санхүүгийн тайланд 1.1 сая төгрөгийн өглөгийг дутуу тусгасныг залруулав.

4. Бараа материал актлах А/144, А/206 дугаар тушаалаар акталсан 1.4 сая төгрөгийн хөрөнгийг үлдэгдлээр тайлагнасныг залруулав.

Албан шаардлага:

Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийт 3,865.0 сая төгрөгийн 55 гүйлгээнээс 1,244.7 сая төгрөгийн 9 гүйлгээг мэдээлээгүй, зарлагын нийт 2,907.3 сая төгрөгийн 98 ажил гүйлгээнээс 131.7 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй, 270.0 сая төгрөгийн 6 гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан байна. Хөрөнгө зарцуулах 5,493.9 сая төгрөгийн 202 тушаал, шийдвэр гарсан ба системд 312.3 сая төгрөгийн 38 тушаал, шийдвэрийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Мэдээллийг нөхөн байршуулах, хугацаандаа байршуулах, цаашид хугацаа хоцроох, мэдээллийг байршуулахгүй байх зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

Тайлант оны эцэст 0.2 сая төгрөгийн авлага, 7.8 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн баталгаажуулаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Ерөнхий нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэгтэй” гэсэн заалтыг хэрэгжүүлж өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

Зөвлөмж:

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Ажил гүйлгээний ангитай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд Нахиа импекс ХХК руу шилжүүлсэн эмийн үнэ болох 0.9 сая төгрөгийн төлбөрийн хүсэлт болон анхан шатны баримт байхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.5 заалтыг баримлан ажиллах, анхан шатны баримтыг бүрдүүлэх

6.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Дорноговь аймгийн Эрүүл мэндийн газар	1	1	-	-	1	-	-	-
НИЙТ									

6.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Дорноговь аймгийн Эрүүл мэндийн газар	7	125.8	4	116.9	-	-	2	8.0	1	0.9
НИЙТ		7	125.8	4	116.9	-	-	2	8.0	1	0.9